Өмнөх оны 9759.5 мянган төгрөгийн авлагын бүрэн барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 42737,6 мянган төгрөг болж 913,6 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн эрхлэгчийн 2020.06.02 ний 30 тоот тушаалаар 1338,2 мянган төгрөгийн аж ахуй материалыг акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 903338,0 мянган төгрөг болж 36368,5 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх онд авлагаар тусгасан 9000,0 мянган төгрөгийн агуулах, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 22120,0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, үнэ төлбөргүй хүлээн авсан 5248,5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 5248,5 мянга, өмнөх оны авлагаар гүйцэтгүүлсэн 9000,0 мянга, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 22120,0 мянган төгрөгийг хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 837282,1 мянган төгрөг болж 2153,0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 2153,0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 444400,4 мянган төгрөг болж, өмнөх оноос 35384,1 мянган төгрөгөөр буюу 8,6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөвт байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 1635,7 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос нэмэгдсэнтэй, тусламж санхүүжилтийн орлого 33748,4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 25456,6 мянга, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 6888,2 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн орлого 2614,5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 442311,8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 22077,3 мянган төгрөгөөр буюу 5,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, элэгдлийн зардал нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 539845,9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 539845,9 мянган төгрөгөөр, хүүхдийн тоог 165, ажиллагсдын тоог 26 орон тоогоор тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 63706,3 мянган төгрөгөөр бууруулж 476139,6 мянган төгрөг, хүүхдийн тоог 200, ажиллагсдын тоог 25 орон тоогоор баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 476139,6 мянган төсөв батлагдаж 2 удаа тодотгол хийн 436537,4 мянган төгрөгийн төсөв баталснаас 368894,6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 67642,8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 368894,6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 67642,8 мянган төгрөгийг зарцуулж 7056,5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 429480,8 мянган төгрөг буюу 98,3 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 789,3 байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 1099,0 мянга, хангамжийн материалын зардлыг 61,0 мянга, нормативд зардлыг 55,0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 5049,0 мянга төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээний 7056,5 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт-2 Төсийн гүйцэтгэлийн тайлан /хөтөлбөр, арга хэмжээгээр/

төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	436,537,400.00	429,480,853.87	7,056,546.13	98.4
АРГА ХЭМЖЭЭ 80109 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардал				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,642,800.00	66,543,710.00	1,099,090.00	98.4
УРСГАЛ ЗАРДАЛ	67,642,800.00	66,543,710.00	1,099,090.00	98.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,642,800.00	66,543,710.00	1,099,090.00	98.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,642,800.00	56,543,710.00	1,099,090.00	98.1
Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,450,100.00	26,395,100.00	55,000.00	99.8
УРСГАЛ ЗАРДАЛ	26,450,100.00	26,395,100.00	55,000.00	99.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,450,100.00	26,395,100.00	55,000.00	99.8
Норматив зардал	26,450,100.00	26,395,100.00	55,000.00	99.8
АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	150,600.00	150,600.00	-	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	150,600.00	150,600.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,600.00	150,600.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	150,600.00	150,600.00	-	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	313,525,700.00	312,707,243.87	818,456.13	99.7
УРСГАЛ ЗАРДАЛ	313,525,700.00	312,707,243.87	818,456.13	99.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,525,700.00	312,707,243.87	818,456.13	99.7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	248,935,500.00	248,146,106.78	789,393.22	99.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	31,117,000.00	31,113,937.09	3,062.91	100.0
Норматив зардал	13,355,500.00	13,355,500.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	3,047,000.00	3,021,000.00	26,000.00	99.1
Эд хогшил, урсгал засварын зардал	6,030,900.00	6,030,900.00	-	100.0
Томилголт, зочны зардал	140,600.00	140,600.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	941,400.00	941,400.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	9,957,800.00	9,957,800.00	-	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,768,200.00	23,684,200.00	5,084,000.00	82.3
УРСГАЛ ЗАРДАЛ	28,768,200.00	23,684,200.00	5,084,000.00	82.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,768,200.00	23,684,200.00	5,084,000.00	82.3
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	19,688,100.00	19,688,100.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	2,461,100.00	2,461,100.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	1,570,000.00	1,535,000.00	35000	97.77
Эд хогшил, урсгал засварын зардал	5,049,000.00	-	5049000	0.00

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 2614,5 мянга төгрөгийн орлогыг төвлөрүүлж ангилал зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 49140,3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 2423,9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож 33558,3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 13158,1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Байгууллагын даргын буруутай үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас ноогдуулсан 500,0 мянган төгрөгийн шийтгэврээс 421.4 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрөөс төлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 14 ний өдрийн 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоож буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр шийдвэрлэв.

2. Цалингийн зардлыг давтан тооцоолол хийхэд дарга нягтлан бодогчийн цалингийн шатлалыг буруу тогтоож 1,2 дугаар саруудад 55.2 мянган төгрөгийг илүү бодож өгсөн, тушаал шийдвэргүй 25 ажилтанд 375,0 мянган төгрөгийг түлшний хөнгөлөлтийг цалингийн зардлаас олгосон, сахилгын шийтгэл ноогдуулсан 7 албан хаагчид 1572.3 мянган төгрөгийг үр дүнгийн урамшуулалд олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3 дахь "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоож 2172,2 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр шийдвэрлэв.

3. Баянхонгор аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.1.26 ний өдрийн 111/шш2018/0001 тоот шийдвэрээр аймгийн Засаг даргын 2017.03.07 ний Б/202 тоот захирамжаар ажлаас чөлөөлөгдсөн Б.Пүрэвтогоод ажлаас халагдсаны цалинд 6459,3 мянга, НДШ-д 1370,0 мянган төгрөг нийт 7829,3 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. Байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 20 ний өдрийн 79 тоот тушаалаар томилсон тооллогын комисс нь эд хөрөнгийг данс бүрээр хөрөнгийн журналаар тоолоогүй, эм, бичиг хэрэг аж ахуйн материал, бусад хангамжийн материалын тоолсон бүртгэл байхгүй, хүнсний материалын 1069.6 мянган үлдэгдэл дутагдсаныг бэлтгэн нийлүүлэгчид хүлээлгэн өгсөн гэж тайлбар хийсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн

хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын өмч хөрөнгийн тооллогыг 2021.04.10-ны дотор хийж баталгаажуулан зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

1.1.Илрүүлэлт: Тайланд онд 15294.4 мянган төгрөгийг бусад байгууллагад шилжүүлж шууд зардлаар тайлагнасан, анхан шатны баримтын дагуу бараа худалдан авсан, урсгал засвар хийлгэсэн нь тодорхойгүй, нярав орлого аваагүй, тайланд тусгагдаагүй нотлох боломжгүй.

-“БМБМОЖ”-ХХК-аас хөгжим тоглоом худалдан авахаар 6750,0 мянган төгрөгийг шилжүүлсэн, тухайн хөрөнгөөс 2345,0 мянган төгрөгийн тоглоомын багцыг аудитын явцад үзэхэд аваагүй тус байгууллагаас бэлэн мөнгийг гаргуулж авсан.
- “Дэлгэрэх Их богд” ХХК-аас 7020.0 мянган төгрөгөөр дрож худалдан авахаар мөнгийг шилжүүлж хөрөнгийг хүлээж аваагүй байхад нягтлан бодогч, нярав хөрөнгийг хүлээн авснаар тайланд тусгасан. Мөн нярав Б. Чонцол-д байгууллагын бичиг хэргийн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа гэж 40 хувийн цалин өгдөг боловч зарим саруудад тухайн цалинг дарга, нягтлан бодогч нарт шилжүүлсэн нь нотлогдсон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3. “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.6 дахь “нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”; Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Оршин байх, Эрх ба үүрэг, Тохиолдсон байх,Толилуулга ба тодруулга, Үнэлгээ, Иж бүрэн байх, Хэмжилт, Үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчид албан шаардлага хүргүүлж дээрх зөрчилтэй асуудлыг шалгаж цаашид хуулийн байгууллагад шилжүүлж зөрчлийг арилгах.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 13158,1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

1. Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч аж ахуй нэгж байгууллагад хөрөнгө худалдан авахаар мөнгө шилжүүлж бэлнээр гаргуулан авч өөр зүйлд зарцуулдаг, Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтад үндэслэн бүртгэж, няравын тайлан гараагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгадаг, шууд зардлаар тайлагнадаг явдлыг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргаж байгаа талаар дараагийн аудитаар анхаарч үзэх.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд хийгдсэн ажил гүйлгээнээс 8344,8 мянган төгрөгийн ажил үйлчилгээний төлбөр, томилолт, шагнал урамшуулал зэрэг 15 гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй нягтлан бодогч шууд зардлаар бүртгэсэн, нярвын тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт зөрчсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө", 14.3.1 "анхан шатны баримт бүрдүүлэх", 14.3.2 "журналд бичих", Санхүү, эдийн засгийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ийн мөнгөн хөрөнгийн бүртгэлийг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл: Холбогдох заавар, журмыг мөрдөөгүйгээс зардал буруу илэрхийлэгдэх, хөрөнгө үргүй зарцуулах

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ хийхгүй байх, нярвын тайлан анхан шатны баримтыг хянаж баталгаажуулж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 3300,0 мянган төгрөгөөр дрож, худалдан авч зардлыг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зөвшөөрөлгүй зориулалт бусаар зарцуулсан байх.

2.3. Өгсөн зөвлөмж: Нормын хувцас зөөлөн эдлэл зардал, шуудан холбооны зардлыг зориулалтын дагуу зарцуулж Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын дагуу зардлыг бүртгэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Удирдлагын дээд болон дотоод хяналт

3.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 134 мэдээллийг бүрэн байршуулсан, Үүнээс хугацаа хоцорсон 15 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 43159.2 мянга төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

3.2. Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллүүдээс төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, нэмэлт өөрчлөлт, хөрөнгийн зардал, төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, бонд өрийн бичиг хөрөнгө зарцуулах аливаа шийдвэр, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдэгдэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын мэдээллийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Covid-19 цар тахалтай холбоотой эргүүл, постын хоолны зардалд нийт 390 хүн өдрөөр 7053.8 мянган төгрөг, нэг хүн өдөрт 17486 төгрөг зарцуулсан, постын хоол олгохдоо ирцийн бүртгэлийг тухай бүр баталгаажуулаагүй хоолны меню, нярвын тайлангийн ирц зөрүүтэй. Хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэгч ААНБ-уудаас нийт 1513,3 мянган төгрөгийн гэрээний хавсралтад тусгагдаагүй хүнс, материалыг худалдан авсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаалын 1 дэх "Төрийн албан хаагчийн томилолтын зам хоногийн зардлыг ... аймгийн төвд 14000 төгрөг,....", бэлтгэн нийлүүлэгч аж ахуй нэгж байгууллагуудтай байгуулсан хүнсний материал нийлүүлэхээр захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний 3.1-т бүтээгдэхүүн нийлүүлэх ажлын техникийн тодорхойлолтод тусгагдсан нэр төрлөөр бүтээгдэхүүнийг нийлүүлнэ гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

4.2. Эрсдэл: Covid-19 цар тахалтай холбоотой эргүүл, постын нэг хүн өдрийн хоолны зардлыг нэг өдрийн томилолтын зардлаас хэтрүүлж зарцуулсан байх.

4.3. Өгсөн зөвлөмж: Худалдах худалдан авах гэрээг мөрдөж, гэрээнд тусгагдаагүй хүнс, материалыг худалдан авдаг явдлыг таслан зогсоох, Covid-19 цар тахалтай холбоотой эргүүл, постод зарцуулах нэг хүн өдрийн хоолны зардлыг Сангийн Сангийн сайдын 2017 оны 301 дүгээр тушаалаар баталсан томилолтын зардлын хэмжээнээс хэтрүүлэхгүй баталж зарцуулалтыг холбогдох тушаалын дагуу зардалд бүртгэж байх.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Г.ГАНЧИМЭГ 2021.02.24

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.02.24

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.24

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/52/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэг	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
A	1	2	3	Албан тушаал	Овог нэр
4	5				
1	Тайланд онд 15294.4 мянган төгрөгийг бусад байгууллагад шилжүүлж шууд зардлаар тайлагнасан, анхан шатны баримтын дагуу бараа худалдан авсан, урсгал засвар хийлгэсэн нь тодорхойгүй, нярав орлого аваагүй, тайланд тусгагдаагүй нотлох боломжгүй. - "БМБМОЖ" -ХХК-аас хөгжим тоглоом худалдан авахаар 6750,0 мянган төгрөгийг шилжүүлсэн, тухайн хөрөнгөөс 2345,0 мянган төгрөгийн тоглоомын багцыг аудитын явцад үзэхэд аваагүй тус байгууллагаас бэлэн мөнгийг гаргуулж авсан. - "Дэлгэрэх Их богд" ХХК-аас 7020.0 мянган төгрөгөөр дрож худалдан авахаар мөнгийг шилжүүлж хөрөнгийг хүлээж аваагүй байхад нягтлан бодогч, нярав хөрөнгийг хүлээн авснаар тайланд тусгасан -Нярав Б. Чонцол-д байгууллагын бичиг хэргийн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа гэж 40 хувийн цалин өгдөг боловч зарим саруудад тухайн цалинг дарга, нягтлан бодогч нарт шилжүүлсэн нь нотлогдсон.	24659.4	Албан шаардлага өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
2	Баянхонгор аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017.1.26 ний өдрийн 111/шш2018/0001 тоот шийдвэрээр тус цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан Б.Пүрэвтогоод ажлаас халагдсаны цалинд 6459,3 мянга, НДШ-д 1370,0 мянган төгрөг нийт 7829,3 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон.	7829.3	Албан шаардлага өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
3	Байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 20 ний өдрийн 79 тоот тушаалаар томилсон тооллогын комисс нь эд хөрөнгийг данс бүрээр хөрөнгийн журналаар тоолоогүй, эм, бичиг хэрэг аж ахуйн материал, бусад хангамжийн материалын тоолсон бүртгэл байхгүй, хүнсний материалын 1069.6 мянган үлдэгдэл дутагдсаныг бэлтгэн нийлүүлэгчид хүлээлгэн өгсөн гэж тайлбар хийсэн.	1069.6	Албан шаардлага өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
4	Байгууллагын даргын буруутай үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас ноогдуулсан шийтгэврээс 421.4 мянган төгрөгийг төсвөөс төлж зардлыг зориулалт бусаар зарцуулсан	421.4	Төлбөрийн акт тогтоох	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
5	Байгууллагын дарга нягтлан бодогчийн цалингийн шатлалыг буруу тогтоож 1,2 дугаар саруудад 55.2 мянган төгрөгийг илүү бодож өгсөн, тушаал шийдвэргүй 25 ажилтанд 375,0 мянган төгрөгийг түлшний хөнгөлөлтийг цалингийн зардлаас олгосон, сахилгын шийтгэл ногдуулсан 7 албан хаагчид 1572,3 мянган төгрөгийг үр дүнгийн урамшуулал олгосон.	2002.5	Төлбөрийн акт тогтоох	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
6	Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 3300.0 мянган төгрөгийг "Ихэр хүрэн ишиг" ХХК-д дрож худалдан авахаар шилжүүлж зардлыг зөвшөөрөлгүй зарцуулсан.	3300.0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
7	Тайлант хугацаанд хийсэн гүйлгээнээс 8344,8 мянган төгрөгийн ажил үйлчилгээний төлбөр, томилолт, шагнал урамшуулал зэрэг 15 гүйлгээ тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн, няравын тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт зөрчсөн байна.	8344.8	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
8	Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих мэдээллээс хугацаа хоцорч мэдээлсэн 15 мэдээлэл цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 43159.2 мянга төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан		Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

A	1	2	3	4	5
9	Covid-19 цар тахалтай холбоотой эргүүл, постын хоолны зардалд нийт 390 хүн өдрөөр 7053.8 мянган төгрөг, нэг хүн өдөрт 17486 төгрөг зарцуулсан, постын хоол олгохдоо ирцийн бүртгэлийг тухай бүр баталгаажуулаагүй хоолны меню, нярвын тайлангийн ирц зөрүүтэй. Хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэгч ААНБ-даас нийт 1513,3 мянган төгрөгийн гэрээний хавсралтад тусгагдаагүй хүнс, материалыг худалдан авсан.	1513.3	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
10	Бараа материалын дансанд 12 нэр төрлийн 20 ш 5569.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн.	5569	Санхүүгийн тайланд залруулга хийв.	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
11	Шатахууны зардлаас тайлан гаргаагүй 250,0 мянган төгрөгийн орлогыг тайланд тусгасан 125,0 мянган төгрөгийг шууд зардлаар, 225,0 мянган төгрөгийг тохируулах бичилт хийж хаасан.	350	Санхүүгийн тайланд залруулга хийв.	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
12	2021 оны 1 сард орон нутгийн хөрөнгө оруулалтаар олгосон 7136,6 мянган төгрөгийн тоглоом, тоног төхөөрөмж үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч тайланд тусгасан	7136.6	Санхүүгийн тайланд залруулга хийв.	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Тулгаа, Ц.Занабаяр
	ДҮН	62195.9			

_____оОо_____